

ЭКОЛОГИЙН ГЛОБАЛЬ АСУУДАЛ БОЛ НИЙГЭМ-ТЕХНИКИЙН ФИЛОСОФИЙН СУДЛАГДАХУУН БОЛОХ НЬ

Б.ПҮРЭВСҮРЭН

ШУТИС, Хүмүүнлэгийн Ухааны сургууль,
Философи-Соёл судлалын профессорын баг
puujgee@must.edu.mn

Түлхүүр үг: экологийн глобаль асуудал, технократизм, индустриализм, ноосфери, биосфери, коэволюци, экологизаци

Экологийн асуудлыг эдүгээ экологийн бумеранг¹ хэмээн нэрийдэх болжээ. Тэр дундаа экологийн нөхцөл байдал, түүний глобаль асуудлууд хүн төрөлхтний хамгийн тулгамдсан асуудал болж, түүнийг хэрхэн даван туулах талаар эрчимтэй хэлэлцэх болсон. Энэ хэлэлцүүлэгийн дунд техник, экологийн философи² өөрийн байр суурь, зорилготойгоор оролцож эхэлсэн хэмээн үзэж тухайлсан сэдвийн хүрээндээ уг онцлогийг тодруулах зорилгыг агуулав.

Үүний тулд экологийн глобаль хэмээх асуудлыг тодотгох, ямар асуудлууд түүнд багтан ордог, тэдгээр нь философийн судлагдахуун байх боломжийн талаар нийгэм-техникийн хандлагийн үүднээс авч үзэх нь энэхүү өгүүллийн гол зорилго болой.

Хэдийгээр тус өгүүлэлийг "экологийн глобаль асуудал ба технократи иргэншлийн төлөвшлийн харилцан хамаарлын өнөөгийн асуудал" хэмээн нэрлэж болох боловч нийгэм-техникийн философид хэрхэн судлагдахуун болж буйг тодотгох анхны зорилгын хүрээнд ийнхүү нэрлэв.

Экологийн асуудлыг хамрах хүрээ, багтаамжаар нь

1. Локаль /орон нутгийн хэмжээний/ асуудал
2. Региональ /бүс нутгийн шинжтэй/ асуудал
3. Глобаль /дэлхийн хэмжээний/ асуудал

хэмээн ангилж болно. Ерөөс экофилософи буюу экологийн философи гарал үүслээрээ глобаль асуудалтай холбоотойг судлаачид тогтоожээ.

Экологийн глобаль асуудалд хүн, нийгмийн ямар асуудал багтаж буйг ангилах нь хялбар биш хэдийч судлаачийн хандлага, арга зүйгээс хамаарах дамжиггүй. Гэвч судлаачдын хийсэн судалгаанд тулгуурлан дараахь байдлаар ангилж байна.

¹ Бумеранг – [англ. boomerang < австрали.] Эртний Египет, Энэтхэг, Азийн зарим улсуудад хэрэглэгдэж байсан матигар хэлбэрийншиддэг зэвсэг. Эдүгээ Австралид ч ангийн болон тоглоомын хэлбэрээр өргөн тархсан шидсэн байгаа онохгүй бол эргэж өнөх багаж хэрэгсэл.

² Философийн салбар ухаан

1. Халуун-цөмийн асуудал. Нийгмийн хэрэглээний нөхцлөөс үзвэл нэг жилд хэрэглэх нефтийн хэрэглээ асар их буюу наад зах нь гурван тэрбум тонн ажээ. Тодорхой бүс нутгуудад эрчим хүчийг янз бүрийн хэлбэр, хэмжээгээр хэрэглэдэг боловч нийгэм энергийг асар их хэмжээгээр хэрэглэдэх болжээ.
2. Үүний уршгаар байгаль орчин асар их бохирдох болсон. Техникийн философи нь үүнийг хүн төрөлхтний хувьд амьдралын аюулгүй байдал, техникийн ослын төрлүүдийг шинээр нэмэгдүүлэх, цаашилбал цөмийн катастрофи болон терроризмын аюул занал бий болоход хүргэж байна хэмээн үздэг. Энэ бол аж үйлдвэржилттэй олон талаар холбоотой. Үүнийг дулааны цахилгаан станц цаашид бүрэн хангаж чадах уу гэсэн асуудлыг үүсгэдэг. Энэ нь дэлхийн экологийн тэнцвэртэй байдал буюу экосистем, биосферид нөлөөлөн атмосфер, гидросфер, литосферийг их хэмжээгээр бохирдуулдаг. Энэ нь "озоны цоорхой" "цэвэр усны нөөц" "химижилт" болон "хотжилт"-ын сөрөг үр дагавар хог хаягдлын улмаас болох хөрсний бохирдол зэргээс илэрдэг. Ингэснээр биосфер бүтцээрээ бохирдож экологийн харилцаанд тэнцвэртэй оролцох боломж буурч эхэлжээ.
3. Хүн амзүйн асуудал буюу дэлхийн хүн амын тоон өөрчлөлтийн динамик асуудал. Орчин үед "хүн амзүйн хувьсгал" гэж нэрлэгдэх энэ үзэгдэл зарим бүс нутагт хамгийн тулгамдсан асуудал болж 1 км квадрат нутагт амьдрах хүний тоо эрс өссөнөөс харагддаг болж энэ нь хүн төрөлхтний хувьд нүүх үү? Суух уу? гэсэн хоёрдмол хувилбарт тулж ирсэн байна. Дэлхийн хүн амын хувьд аюулт өвчний нэр төрөл улам олширч, хүний экологид түгшүүр төрүүлж байна. Тухайлбал зүрх судасны гарвальтай өвчин тооны хувьд тэргүүлж, хорт хавдарын өвчний нэр төрөл удаалж бусад вирусын болон дархлалын өвчин нийтлэг болжээ¹.

Дээр дурьдсанаас үзвэл глобаль асуудлууд хүний асуудал болох нь илэрхий бөгөөд хүний ахуйн өөрчлөлт бүхий феномен, цаашилбал ертөнцийн талаарх хүний болон шинжлэх ухааны дүр төрх өөрчлөгдөж, ертөнцийг үзэх үзэлд хувьсгал болсонд тооцож болох юм. Энэ утгаараа экологийн глобаль асуудал нийгэм-техникийн философийн судлагдахуун,

¹ Крапивенский С.Э., Социальная философия. М.,1998. г. стр. 186., Вишев Б.В., Ханжин Б.М., Ханжин Т.Ф., Экофилософия: современные проблемы и перспективы решения: Учебное пособие. Челябинск.,1999. г. стр.4

анализын оногдохуун болж хувьсан өөрчлөгдсөн гэж зарчмын хувьд үзэж болох юм.

Одоо өгүүлэн буй санаагаа тодруулахын тулд асуудлыг экологи, техник, нийгмийн философийн зааг уулзвар дээр задлан шинжилэх нь зүйтэй юм. Философи бүхэн өөрөө хүний философи байдаг гэсэн утгаараа аливаа салбар философийн судлагдахуун хүний тухай асуудал болдог билээ. Гэтэл экологийг судлагдахууны гол хүрээ болох нийгмээс байгальд хандах харилцан хамаарлын үр дагаварын үүднээс авч үзвэл экологи бол хүний экологи байдаг. Иймд техникийн болон экологийн философи нэгэн адил зөвхөн хүний тухай философи болно.

Антропозэкологи тодорхой утгаараа нийгмийн экологийн хэсэг эсвэл бие даасан иж бүрэн салбар шинжлэх ухаан болох тул нийгэм-техникийн философид экологийн асуудал судлагдахуун болох бүрэн үндэслэлтэй байна.

Техник түүний хөгжил, дэвшил иргэншлийн тогтолцоонд гүйцэтгэж ирсэн үүрэг ач холбогдолоороо нийгмийн хөгжлийн түүхийг тодорхойлсоор ирсэн ба энэ үүднээс "хүн төрөлхтний түүх бол зөвхөн багаж хэрэгсэлийн төгөлдөржилтийн түүх" гэж үзэх нь бий. Тэр дундаа одоогоос 300 гаруй жилийн өмнөөс эхэлсэн аж үйлдвэржилт нь эдүгээ техникийн гарвальтай иргэншил буюу технократист, техноген, технотрон, постиндустриаль нийгэм гэх мэтээр нэрлэхэд мөн л хүргэсэн билээ. Энэ бүх тодотголууд угтаа өнөөгийн нийгмийн шинж төрх, орчин, хүн төрөлхтний глобаль гэгдэх асуудалтай холбоотой юм.

Гэтэл дээрх асуудал бүхэн нэн тэргүүнд хүний асуудал байхаас гадна философийн хувьд ёс зүйн асуудал болж буй нь экологийн асуудал философийнх болон хувирч байгааг харуулдаг. Цаашилбал цөмийн, био, эмнэлэгийн, инженерийн, компьютерын, сансарын зэрэг ёс зүйн салбарууд үүссэн нь үүнийг харуулна. Мөн байгаль, нийгмийн харилцан хамаарлын зөрчилт байдал экологийн асуудлыг тодорхойлоход хүргэдэг. //

Экологийн асуудал философийн асуудал болохын хувьд түүнд:

- ертөнцийг үзэх үзлийн шинж
- аргазүйн шинж
- амьдралын утга учирын шинжтэй буй эсэхийг харгалзан үзэх ёстой.

Аж үйлдвэржсэн нийгмийн хөгжлийн явцад зарим асуудал ч шинээр глобаль статустай болон хувирч байна. Үүнд олон улсын терроризм, спид, хар тамхи гэх мэт.

Гэтэл эдүгээгийн хүн амын өсөлтөөс бусад нь глобаль асуудлууд шууд утгаараа шинжлэх ухаан техникийн хувьсгалтай холбоотой гарч ирсэнээрээ онцлог бөгөөд энэ нь аж үйлдвэржсэн буюу технократи нийгмийг "санамсаргүй"¹ гэж үзэхэд хүргэсэн болов уу.

Аж үйлдвэржсэн нийгмийн тухай Э.Тоффлер өгүүлэхдээ энэхүү технократ нийгмийн төлөвлөлт дараахь онцлогтой хэмээжээ. Үүнд:

- 1) технократ төлөвлөгөө ба энэ нь индустрализмын гол бүтээгдэхүүн, үнэнт зүйл буюу "эдийн засгийн төвлөрөлтийг" шаарддаг
- 2) технократ төлөвлөгөө нь индустриализмын субъектив парадигм бөгөөд энэ нь өнөөд хандсан "богино хугацааны", ухвар мөчид үйлдэл байсан. Тухайлбал таван жилийн төлөвлөгөө гэх мэт ба Зөвлөлт Холбоот улсад энэ хөдөлгөөн 1920-оод оноос эрчимтэй эхэлсэн ажээ. Гэтэл томоохон корпорациуд одоо 10, 20 түүнээс цааших стратегийн төлөвлөлтийг шаардах болсон.
- 3) Технократи байгуулал ихээхэн хүнд сурталт шинжтэй ба энэ хирээрээ "ардчилсан бус" байдаг хэмээжээ.²

Экологийн асуудлаар эдүгээ бас л хоёрдмол хандлага урган гарч ирсэн ба энэ нь экологийн пессимизм ба оптимизм юм. Энэхүү дилемм техникийн философийн хөгжлийн эхэн үед ч анх үйлчилж байсан түүхтэй.

Эдүгээ экологийн тэнцвэртэй байдлыг хадгалах, биосферийг эвдэхгүйгээр нийгэм-техникийн хөгжлийг хангах тухай коэволюцийн³ үзэл санаа ч бий болжээ. Уг ойлголтын анх Эрих Янч⁴ хэмээх судлаач хэрэглэсэн ба коэволюци өөрөө хүний хувьд коадаптацииг хүлээн зөвшөөрдөг. Үүний тулд экологийн соёлыг төлөвшүүлэх, тэр хүрээндээ экологийн зохистой агуулга бүхий ухамсарыг төлөвшүүлэх улмаар экологийн хүмүүжил, боловсролыг олгох нь энэ тэргүүний зорилго байх ба түүндээ шашин-ёс суртахууны олон янзын сэдэл-үүсгэлийг⁵ ч ашиглаж болох юм. Тухайлбал онгон дагшин

¹ Майкл Харрингтон хэмээх судлаач "манай зуун бол санамсаргүй" шинжтэй гэж үзжээ. // Э.Тоффлер. Шок будущего. стр.488

² Э.Тоффлер. Шок будущего. стр.488

³ Коэволюци – coevklution. [лат. со + evolutio буюу тухайн газар нь дэлгэрүүлэх, задлах] гэсэн утгатай ба зөвшөөрөгдсөн хувьсал, хөгжил хэмээн ойлгож болно. Үзэл баримтлал болохын хувьд байгаль нийгмийн хамтын хөгжлийн гармоник зарчим бол хүн төрөлхтний ирээдүйн хөгжил, оршихуйн зайлшгүй нөхцөл байх болно хэмээх санаа юм. Иймд энэ нь чиглэлийн хувьд экологийн оптимист үзэл юм.

⁴ Jantsch E. The self-organizing Universe: Scientific and Human Implications of the Emerging Paradigm of Evolution. Oxford etc.1984. // Е.Н. Шульга Генезис идей коэволюции.

⁵ Борейко В.Е. Популярный словарь по экологической этике и гуманитарной экологии. Киев: КЭКЦ 2003 г. // www.biospace.nw.ru/ecoethics/dict_main.html

байгалиа хамгаалах явдал нь хүний сайн үйлийн нэг, түүнд үзүүлж буй талархал, түүнийг хайрлаж буйн илэрхийлэл, ерөөс байгаль бол хамгийн ариун дагшин, гоо үзэсгэлэн мөн гэх мэтээр үзэхэд оршдог. Монгол улсын үндсэн хуулинд энэ талаар "хүний журамт үүрэг" гэсэн тодотголоор оруулсан байдаг. Зарим судлаачдын үзсэнээр дээр дурьдсан асуудлын хүрээнд хорин дөрвөн сэдлийг заасан байх ба экологийн асуудал энэ хирээрээ шашин, ёс суртахуунтай хэзээд холбоотой болохыг үзүүлж буй нь мөн л философи үндэслэлтэй буюу ертөнцийг үзэх үзлийн агуулгатай байдлыг харуулна.

Эдүгээ нийгмийн ухамсарын уламжлалт олон хэлбэрүүд үйлчилдэг ч шинжлэх ухаан техникийн эрин үетэй холбоотойгоор экологийн ба шинжлэх ухааны ухамсар хэмээх хоёрдмол шинэ хэлбэр үүссэн явдал үүнийг улам бүр тодотгож байна. Цаашилбал экологийн ба компьютерийн ёсзүйн¹ салбар техникийн философид хамгийн орчин үеийн асуудал, судлагдахуун болон тавигдаж буйг ч тэмдэглэхэд илүүдэхгүй юм. Экологийн ёс зүйн асуудлыг анх удаа Томист философичид цөмийн зэвсэглэлээр хөөцөлдөх нь дэлхийн экосистемд химийн бохирдол үзүүлэх аюултай зэргээр дэвшүүлж байсан гэх ба жам ёсны эрхийн онолчид ч дэмждэг ажээ. Мөн онц шаардлагагүй үед мэдрэх чадвартай амьтныг зовоохгүй байх гэсэн зарчим нь утилитаризм, деонтологид ихээхэн хамаатай ба орчны бохирдолын асуудлыг газрын бус орчин дэлгэрүүлэн авч үзсэнээр дэлхий орчмын агаар мандлыг сансрын хөлөг, багаж хэрэгсэлийн хог хаягдлаар хэт ачаалж болохгүй гэж үзсэнээр сансрын ёс зүй хэмээх шинэ салбар үүсэхэд хүргэж байна. Энэ талаар Э.Тоффлерын өмнө дурьдсан бүтээлд тусгалаа олсон ба "Сансрын орчлон дахь баяр ёслол" хэмээх нэрийн доор авч үзсэн байдаг. Түүнчлэн нийгмийн мобиль шинжийн илэрхийлэл болсон хөдөлгөөний төрөл болох "ногоонтны хөдөлгөөн" "экуменист хөдөлгөөн" "экологийн (ногоон) соёл" зэрэг нэртэйгээр арга хэмжээг глобаль байдлаар өрнүүлэх болсон.

Одоо экологийн глобаль асуудлууд ноосфер²-тэй хэрхэн хамааралтай болох талаар авч үзье. Үүнийг авч үзэхийн тулд экологийн асуудалд ертөнцийг үзэх үзлийн үүднээс хандаж байна.

¹ Митчем К. Техникийн философи УБ.,2002 Орч. А. Энхбаатар х.64 Энэ чиглэлийн гол бүтээл нь Man's Responsibility for nature 1974 нэртэй бүтээл ажээ.

² Ноосфер – [грек. nous-оюун ухаан + sphaira-бөмбөрцөг, хүрээ гэсэн үг] Биосферийн хөгжлийн дээд шат бөгөөд хүн төрөлхтний иргэншлийн үүсэл, бүрдэлтэй холбоотойгоор зорилго чиглэлтэй хөгжлийг тодорхойлогч хүчин зүйл болох оюун ухаант үйлдлийн төрөл бий болсоноор үүссэн. Уг нэр томъёог анх Э.Леруа, Тейяр де Шарден нар хэрэглэсэн гэж үздэг.

Философи сэтгэлгээ үүсэн хөгжиж эхэлсэн эртний грекийн философи нь өөрөө космоцентрист хэв маягт захирагдаж байсан нь сонирхолтой байж болох ба философи байгалийн үүсэл, бүтэц, зүй тогтолын асуудлыг судлан шинжлэхээс буюу натурфилософиос эхэлсэн билээ. Энэ уламжлал шинжлэх ухааны хөгжилд хадгалагдсаар эдүгээ хүрч танин мэдэх, бүтээн туурьвих үйл ажиллагааны явцад биосферийн ерөнхий амьдрал ноосферийн хөгжил, бие даасан байдлыг хангасаар ирсэн ба К.Попперын "объектив мэдлэгийн үзлийг" түүнд жишээ болгож болох юм.

Улмаар биосфер өөрийн хүрээндээ ноосферийн тэлэлт хийгээд зогсохгүй асуудлыг авч үзэх бие даасан хүрээнүүд болох социосфер, антропосфер, техносферийг бий болгосноор биосфер¹-ийн эрчимтэй хувьсал явагдаж ноосфер энергийн шинэ эх булаг болохоо харуулж байна. Иймд түүнийг ноосфер бол хүч хэмээн Ф.Беконийн уламжлалыг өргөтгөж болох юм. Техникийн энэхүү хөгжил дэвшил өөрөө хүний биоритмд эсрэг шинжтэй боловч хүн түүндээ дасан зохицох буюу коадаптацид орох шаардлага гарч ирдэг. Сонирхолтой нь хүн техник, технологийн орчинд дасан зохицох чадварын судалгааг хийж эхэлсэн ажээ.

Үүнийгээ OLIVER²-ийн судалгаа хэмээжээ. Судалгааны зорилго нь аж үйлдвэржилтийн явц дахь шинэ шинэ техник, процесс хүнээс дасан зохицох чадвар шаардаж буйг харуулах ба соёлын шинэ хэв маягийн сонголт хүлээгдэж буйг илэрхийлж байдаг. Угтаа энэ нь техникийн программчлал био программчлалын адилсал, зохицолын момент юм. Жишээ болгож мэдээллийн алба болон эмнэлэг, дэлгүүр, худалдаа, үйлчилгээний байгууллагад ажиллагсадын онцлогийг дурьдаж болох юм. Түүний сөрөг илрэлийг З.Фрейдийн "невроз бол иргэншлийн хариу өр төлөөс" гэсэн үгээр хариулж болох юм.

Дүгнэлт

¹ Биосфер – [грек bios-амьд+ sphaira-бөмбөрцөг, хүрээ гэсэн үг] Амьд организмын орших талбар. Түүнд атмосферийн доод, гидросфер бүхлээрээ, литосферийн дээд үеүүд багтах ба дэлхийн хамгийн том экосистем юм. Тэрээр юмс үзэгдлийн биотик эргэлт, солилцоог буюу байнгийн амьд эргэх холбоог илэрхийлнэ. Уг нэр томъёог анх нэрт эрдэмтэн Вернадский хэрэглэсэн.

² On-Line Interactive Vicarious Expediter and Responder гэсэн үгсийн товчлол ба уг үзэл баримтлалын зохиогч болох Оливер Селфридж оорнийнхоо нэрийг шингээх замаар нэрлэжээ. // Э.Тоффлер Шок будущего. М.,2002 стр. 473.

Экологийн глобаль асуудал үүссэн нь техникийн дэвшлийн хувьд аж үйлдвэржилтийн олон салаа үзүүлэлтүүдтэй, шинжлэх ухааны хөгжлийн хувьд сциентизмын үнэлэмж өндөрссөнтэй, нийгэм-соёлын хувьд нийтийн соёлын элементүүд түгэн тархаж, хэрэглээний төрөл хүрээ өргөссөнтэй, нийгмийн динамикийн хувьд социаль мобиль шинж ихсэж, социаль үйлдэл, үйл ажиллагааны хувьд хүн төрөлхтөн улам бүр глобальчлагдах болсонтой холбоотой байна. Тэдгээр нь цагаачлал ба национализм, терроризм, глобализм ба антиглобалист зэрэг дэмжсэн болон эсэргүүцсэн хөдөлгөөнүүдээр илэрдэг. Гагцхүү энэ бүх оршихуйн төлөөх хөдөлгөөн нь аж үйлдвэржилтийн улмаас дэлхий дахинаа шинэ эмх журмыг шаардахад хүргэж болох юм. Электрон засаглалыг үүний илрэл гэж үзэж болно.

Экологийн глобаль төдийгүй локаль геоэкологийн эрс өөрчлөлт нийгэмд гэнэтийн өөрчлөлтийг дагуулдаг болох нь олон баримтаас харагдаж байна. Мөн экологийн глобаль асуудал нь нийгмийн харилцаа, тэр дундаа эдийн засгийн харилцаа, хөгжилтэй нэн хамааралтай болохыг дэлхийн эдийн засгийн 1973-1974 оны хямрал, Бреттон-Вудскийн валютын системийн өөрчлөлт, дэлхийн хоёрдугаар дайн, таван жилийн төлөвлөгөө зэрэгтэй холбон үзвэл эдүгээгийн экологийн глобаль асуудлын үндэс хорьдугаар зууны 20-30-аад оны үед тавигдсан хэмээн үзэх ёстой болж байна.

Ийнхүү экологийн глобаль асуудал, хүчин зүйл эдүгээ ертөнцийг үзэх үзлийн шилжилтэнд хүчтэй нөлөө үзүүлж энэ хирээр ертөнцийг үзэх үзлийн экологизаци ид явагдаж байна.

Ашигласан ном зохиол

1. Борейко В.Е. "Популярный словарь по экологической этике и гуманитарной экологии" Киев., 2003 г.
2. Вишев И.В, Ханжин Б.М, Ханжина Т.Ф. Экофилософия: современные проблемы и перспективы решения: Челябинск. 1999. г.
3. Горохов В.Г. Розин В.М. "Введение в философию техники" М., 1998 г.
4. Глобализация в социально-философском измерении. Сборник материалов конференции. СПб: 2003 г.
5. Крапивенский С.Э. "Социальная философия" Дон.Рос. 1998
6. Кобылянский В.А. "Философия экологии" М., 2003 г.
7. Митчем.К "Техникийн философи" УБ., 2002 он Орч.А.Энхбаатар
8. Хмылев П.Н. Глобализация как социально-философская проблема //
9. Тоффлер Э. "Шок будущего" М., 2002. г.

10. Философский энциклопедический словарь М., 1999. г.

11. Философия Под.ред А.Ф.Зотова, В.В.Миронова, А.В.Разина М.,
Трикста. 2004. г. Стр.661-670

Ашигласан web хуудас

www.glossary.ru/

www.anthropology.ru

www.philosophy.ru

www.countries.ru/library

www.fonetix.ru/mater/dictionary